



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/47

Дуурсах

Г Сургалт зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалтууд, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/43 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл, стратегийн худалдан авалт, эмнэлгийн бие даасан байдлын чадавх бэхжүүлэх” сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сургалтын удирдамжийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтын үйл ажиллагааг удирдамж, хөтөлбөрийн дагуу үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих асуудал хариуцсан мэргэжилтэн (А.Ууганцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагаанд шаардагдах 600,000 (Зургаан зуун мянга) төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.


5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.

ДАРГА

 Н.ЭНХЖАРГАЛ



Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
06... дугаар сарын 23... ны өдрийн
1/47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



УДИРДАМЖ

“Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл, стратегийн худалдан авалт, эмнэлгийн бие даасан байдлын чадавх бэхжүүлэх” сургалт зохион байгуулах тухай

Нэг. Үндэслэл

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 01, 02, 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх.

Хоёр. Зорилго

Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл, стратегийн худалдан авалт, эмнэлгийн бие даасан байдлын чадавх бэхжүүлэхэд төсвийн шууд захирагч, санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулах.

Гурав. Хамрах хүрээ

Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн даатгалын газар, Сум, Өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч, холбогдох эмч, мэргэжилтнүүд.

Дөрөв. Үйл ажиллагаа

Танхимын 2 өдрийн сургалт.


Тав. Хугацаа, зохион байгуулах газар

2022 оны 06 дугаар сарын 28,29-ний өдрийн 09:00-18:00 цагт Аялгуу ресторан.

Зургаа. Үр дүн

Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн санхүүжилт, төлбөр тооцооны программыг нэвтрүүлж, эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулсан байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
0.6 дугаар сарын 22 ны өдрийн
4/17 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ШИНЭЧЛЭЛ, СТРАТЕГИЙН
ХУДАЛДАН АВАЛТ, ЭМНЭЛГИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫН
ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зардлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ |
|---|-------------|-------------|------------|----------------|--------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 2 | Үдийн хоол | ш | 64 | 9,375 | 600,000 |
| | | | | | Нийт 600,000 |

_____оОо_____